

**2021.04.29 14:00 МИНУТ 22-Р БААЗ ХК-ИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

22-р Бааз ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахимаар хуралдав.

Хуралд хувьцаа эзэмшигчдээс:

- “Монгол СекьюритиесҮЦК” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
- Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- З.Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Чингис хаан секьюритиес ХХК 56,870 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/

Нийт 1,945,050 ширхэг буюу нийт гаргасан хувьцааны 73,3 хувийг эзэмшигчид хуралд оролцов.

ТУЗ-ийн гишүүдээс:

- Л.Гүндэгмаа
- П.Эрдэнэчулуун
- Т.Зоригтбаатар
- З.Номундарь
- Т.Эрдэнэбаатар
- Б.Баярсайхан
- Ю.Туяацэцэг
- А.Баатаржав
- Ц.Энхтуяа

оролцов.

Хурлыг Л.Гүндэгмаа удирдав. Хурлын дэг болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг уншиж танилцуулав.

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья.

Тооллогын комиссын дарга Ш.Наранхүү ирцийг танилцуулан тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 73,3% байгаа тул Монгол Улсын компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэв.

Гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт болон ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрүүдийг уншиж танилцуулав. Компанийн үйл ажиллагааг цаашид эрчимжүүлэх, ашгийг нэмэгдүүлэхээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилтийн асуудлыг танилцуулав.

Санал, асуулт эхлэв.

Л.Гүндэгмаа: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал авах асуудлуудаа ерөнхийд нь танилцууллаа. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал маань цахимаар болж байгаа нь их онцлогтой байна. Хуралд оролцож буй та бүхэндээ баярлалаа. Компанийн хувьд энэ цар тахалын асуудал ихээхэн хүнд тусч байна. 2020 онд бид үйл ажиллагааг эрчимжүүлж зарим урсгал засварыг хийж нилээдгүй түрээслэгчдийг татаж орлогыг нэмэгдүүлсэн. Хэдийгээр цар тахлын үе боловч 2020 онд 2019 оны алдагдалтай харьцуулахад 2 дахин бага гарсан. Цаашид ч илүү олон арга хэмжээ авч ажиллахаар, газраа эргэлтэд оруулахаар төлөвлөн та бүхэнд төслийг танилцууллаа. Санхүүжилтийн асуудлыг ТУЗ-д даатгаж эрхийг нь өгөх хэрэгтэй байна. Та бүхэн санал бодлоо илэрхийлээрэй.

З.Номундарь: Төслийг бүрэн дэмжиж байна. Жилээс жилд газрын төлбөр нэмэгдэж орлого төдийчинээ буурч байгаа энэ нөхцөлд компанийг бас тийм ч муугүй ажилласан гэж бодож байна. Гэсэн ч цаашид илүү хичээх хэрэгтэй байна. Зээл авч үйл ажиллагааг дэмжих, газрыг эргэлтэд оруулах нь энэ цар тахлын үед зайлшгүй авах арга хэмжээнүүдийн нэг ч гэж бодож байна. Төр засгаас бага хувийн иймэрхүү нөхцөлтэй зээлээр дэмжиж байгаа дээр авч хохирол багатайгаар цар тахалыг даван туулах нь одоо нэн тэргүүний асуудал болоод байна.

Т.Эрдэнэбаатар: Гүйцэтгэх захирал санхүүгийн тайлан тооцоо аудитын дүгнэлтийг болон төслийн талаар маш ойлгомжтой тайлбарлаж өглөө. Олон зүйл нуршилгүй санал хураалтаа эхлүүлэх санал байна.

Хурлын дарга: Өөр санал хэлэх болон асуулт асуух хүн байвал микрофоноо нээгээд хэлээрэй. Энэ удаагийн хурал маань цахимаар явагдаж байгаа нь компанийн анх удаагийн цахим хурал болж байна. Бидэнд зарим талаараа дутагдалтай зүйлс байвал мөн саналаа хэлж техникийн тал дээр асуух тодруулах зүйлээ чөлөөтэй асууж болно шүү.

З.Номундарь: Энэ цар тахлыг сөрөх, үйл ажиллагаагаа жигдрүүлэх өргөтгөх зэрэг нэн чухал асуудлуудыг компанийн удирдлагууд болон ТУЗ-ийн гишүүд, хувьцаа эзэмшигчид бүгд дэмжиж байгаа учир шууд санал хураалтаа явуулах саналыг дэмжиж байна.

Ц.Энхтуяа: Ер нь энэ цар тахал зөвхөн бидний ч хувьд биш бүх л аж ахуйн нэгж байгууллагын хувьд хүндхэн байдал үүсгэж байна. Гэлээ гээд хүлээж цаг алдалгүй энэ төслийн үйл ажиллагааг шууд эхлүүлэх шаардлагатай байна.

А.Баатаржав: Би ч мөн Энхтуяагийн саналтай санал нэг байна. Үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлыг өмнөх хурлуудаар ч нэлээдгүй ярьсан. Хөл хорио тавигдмагц үйл ажиллагааг эхлүүлэх хэрэгтэй гэж бодож байна.

Хурлын дарга: Нэмж асуулт асуух тодруулах, санал хэлэх хүн байвал микрофон нээлттэй шүү. Мөн цаашид ч бид хурлуудыг нөхцөл байдалд нь тулгуурлан цаг хугацаанд нь хүндрэлгүйгээр хийж байх болно. Анхны удаа учир алдаа дутагдал гарч магадгүй ойлгож хамтарч ажиллана гэж хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд ойлгоно найдаж байна.

За нэмж санал хэлэх хүн гараагүй учир санал хураалтдаа орё гэж бодож байна.

Тооллогын комиссын дарга Ш.Наранхүү хурлаар хэлэлцсэн асуудлуудыг нэгбүрчлэн асууж санал хураалт явуулав.

ХУРЛЫН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Л.ГҮНДЭГМАА

П.Эрдэнэчулуун

Т.Зоригтбаатар

З.Номундарь

Т.Эрдэнэбаатар

Б.Баярсайхан

Ю.Туяацэцэг

А.Баатаржав

Ц.Энхтуяа

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

З.Туул

З.ТУУЛ